БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ДАРГА Э.ЛХАГВАСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1 | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр | Худалдааг хөнгөвчлөх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас хилийн хорио цээрийн хяналт тавих чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэн. Үүнтэй уялдуулан бүрдүүлэлтэд "Хорио цээрийн шалгалт"-ын үе шат нэмэгдсэн. ГЕГ-ын ЭУХ-аас "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны тайлан 2023"-ыг гаалийн бүрдүүлэлтийн үе шат бүрээр хийсэн байна. Судалгааг хийхдээ тухайн жилийн 11 дүгээр сарын 06-11-ний | 1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна.<br><br>2. Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж цаг хугацааг өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар | **Биелэлт:**<br>1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна.<br>Цахимаар өөрөө мэдүүлэх мэдүүлгийн тоо өмнөх оноос 1 хувиар, аж ахуйн нэжг иргэдийн тоо 1993-р, бичлэгийн тоо 0.2 хувиар, нийт татварын дүн 0.7 тэрбум төгрөгөөр тус тус өмнөх оноос өссөн.<br>Гаалийн зуучлагчаар дамжуулж мэдүүлсэн мэдүүлгийн 14.3 хувь, бичлэгийн 3 хувьд алдаа бүртгэгдсэн бол өөрөө мэдүүлсэн мэдүүлгийн 37.2 хувь бичлэгийн 3.9 хувийг алдаж засварт буцаасан байна.<br>Цахимаар өөрөө мэдүүлсэн иргэн аж аухйн нэгжийн алдааны утгыг харахад гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний бичсэн мэдүүлгийн 14 засварт буцаж байхад харьцангуй их буюу 37.2 хувь нь засварт буцсан байна. Мөн барааны үнэ, тоо хэмжээ татвартай холбоотой хүснэгтүүдийг гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээс их засварт буцаалгасан байна.<br>Иргэн аж ахуйн нэгжийн өөрөө мэдүүлэх мэдүүлгийг нэмэх үүднээс 1 минут 30 секундын хугацаатай видео контент, цахимаар өөрөө мэдүүлэх нийт 2 видео контент Олон нийттэй харилцах албатай хамтран бэлтгэж, нийтэд хүртээл болгосон.<br>Бичиг баримтын шалгалт хийхэд нэгж бараанд зарцуулсан хугацааны дунджийн өөрчлөлтийг төлөв тус бүрээр авч үзэхэд тайлант хугацаанд "ногоон" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 17.4 хувиар, "улбар шар" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 26.2 хувиар, | 01.01-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өдрүүдэд хийгдсэн бүрдүүлэлтийн мэдээг сонгож хийсэн. Дээрх судалгаанд импортын гаалийн бүрдүүлэлтэд бичиг баримтын шалгалт хийсэн хугацаа 2022 онд /7005 гаалийн мэдүүлэг/ 194 минут буюу 3 цаг 14 минут байсан бол 2023 онд /7572 гаалийн мэдүүлэг/ 70 минут буюу 1 цаг 10 минут болж 66 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | бууруулсан байна.<br><br>3. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг тухай бүрт нь гарган, МТТ-д хүргүүлсэн байна.. | "улаан" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 26.5 хувиар, нийт нэгж бараанд хийх шалгалтын хугацаа 15.3 хувиар буурсан байна.<br>2024 оны 10 сараас эхлэн япон улсаас импортлогдож буй 8703 зүйлд хамаарах Toyota, Prius суудлын автомашиныг системээс автоматаар үнэлэх ажиллагаа эхэлснээс хойш 3,611 автомашины бичиг баримтын бүрдүүлэлтэнд тэг цаг зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл улаан төлөвөөр тооцоход 111,905 минут хэмнэсэн.<br>Япон-Монголын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болон Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /АПТА/-ийн хүрээнд 2023 онд 5363 гаалийн бүрдүүлэлтээр 334.9 сая ам.долларын бараанд 116.3 тэрбум төгрөгийн татвар ногдуулж барагдуулсан байна. Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулахаар 3554 бичлэг бүхий мэдүүлэгт санал өгч 358 мэдүүлэгт түргэвчилсэн бүрдүүлэлт хийсэн..<br>**Хүрсэн түвшин:**<br>1. Импортын барааны гаалийн бүрдүүлэлтийн 9 хувийг цахимаар өөрөө мэдүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 1993 аж ахуйн нэгж, иргэн нэмэгдэж өөрөө мэдүүлсэн бөгөөд мэдүүлгийн тоо 32.7 хувиар өссөн. Цахимаар өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх үүднээс 2 видео контент бэлтгэж олон нийтийн сүлжээнд тавьсан. Мөн цахимаар өөрөө мэдүүлэх чиглэлээр дүн шинжилгээ хийж санал боловсруулан БАҮХ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>2. Бичиг баримтын шалгалтын хугацааг бууруулах зорилгоор ГУБ нарыг тодорхой бүлгүүдээр буюу автомашины тоног төхөөрөмж, 401, 402, 403 горимд гаалийн бүрдүүлэлт хийлгэхээр салган томилсон. Япон улсаас импортлогдож буй 8703 зүйлд хамаарах Toyota, Prius суудлын автомашиныг системээс автоматаар үнэлэхээр зохион байгуулсан зэрэг ажиллагааны үр дүнд "ногоон" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 17.4 хувиар, "улбар шар" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 26.2 хувиар, "улаан" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 26.5 хувиар, нийт нэгж бараанд хийх шалгалтын хугацаа 15.3 хувиар буурсан байна.. | | |
| 2 | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | ГЕГ-ын даргын 2023.04.17-ны өдрийн А/253 дугаар тушаалаар гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, нүүр тулсан харилцаанаас зайлсхийх, гадаад худалдааг | 1. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | **Биелэлт:**<br>1. Барааны ангилал үнэлгээний хэлтэстэй хамтран гаалийн зуулагч байгууллагуудын удирдлагуудтай хамтарсан уулзалт зохион байгуулах, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүд болон цахим төвийн гаалийн улсын байцаагч нараас Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журамд өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн авч Хуулийн хэлтэст дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор газар хороодод гэрээ байгуулан ажиллаж буй бүртгэгдсэн мэргэжилтнүүдийг судалгаар авч нэгдсэн бүртгэл үүсгэсэн.<br>Холбогдох газраас ирүүлсэн чиглэл, албан бичиг болон холбогдох цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр ГБМ нарт цахимаар болон | 01.01-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөнгөвчлөх зорилгоор УБГГ-т бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг туршилтаар эхлүүлсэн. ГЕГ-ын даргын 2023.06.15-ны өдрийн А/369 тушаалаар харьяа гаалийн газар, хороодын гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийг цахим хэлбэрт шилжүүлэн Бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлсэн. Сангийн сайдын 2024.01.17-ны өдрийн 06 дугаар тушаал, ГЕГ-ын даргын А/123 дугаар тушаалаар ГЕГ болон дэргэдэх байгууллагын зохион байгуулалт, бүтэц орон тоог шинэчлэн баталсан. ГЕГ-ын даргын 2024.03.04-ны өдрийн Б/133 тоот тушаалаар тус төвд ажиллах ГУАБ, ГУБ нарыг томилоод байна.<br><br>- Гаалийн зөрчлийн хувьд Зөрчлийн тухай хуулийн дагуу 2022 онд 105 ГБМ-д, 2023 онд нийт 126 ГБМ-д шийтгэл | 2. ГБМ-ний үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, улирал бүр /нийт 2 удаа/ засварт буцаалтад судалгаа, дүн шинжилээ хийж, санал гарган БАҮХ-т хүргүүлсэн байна.<br><br>3. ГБМ-ийг чадавхижуулах чиглэлд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.<br><br>4. ГБМ-нд оногдуулсан захиргааны зөрчлийн тоог өмнөх оны мөн үеэс 1-ээс доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна. | бичгээр танилцуулж биелэлтийг хanган ажиллаж хэвшил болгон "ГБМ" viber группт тухай бүр мэдээллийг хүргэж ажилласан.<br>2. 2023 оны мөн үеэс 2024 оны мэдүүлгийн тоо 62%-р засварт буцаалтын тоо 28% хувиар өссөн бөгөөд нийт засварт буцаалтын тоог мэдүүлгийн тоотой харьцуулахад 19% хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br>Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18,9% хувиар засварт буцаалтын тоо буурсан байна.<br>Энэ нь Бүрдүүлэлтийн цахим төвийн бичиг баримт хариуцсан ГУБ нарын чадавхыг дээшлүүлэх үүднээс гаалийн бүрдүүлэлтэд гарч буй алдаа, анхаарах зүйлс, гаалийн хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенц, барааны ангилалтай холбоотой гарч буй маргаан барааны үнэлгээтэй талаар нэг мөр ойлголт өгөх зорилгоор долоо хоног бүрийн мягмар гаригт нийт ГУБ нарт тогтмол сургалт явуулсантай холбоотой тодорхой үр дүн гарсан байна.<br>3. – 1, 2-р улиралд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн давтан сургалтуудад холбогдох хууль тогтоомж гаалийн бүрдүүлэлтийн өнөөгийн байдал анхаарах асуудал<br>- 2024 оны 6 дугаар сарын 14-нд 100 гаруй итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн 200 орчим гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэний оролцсон цахим сургалт<br>4. Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 14 дахь хэсгийн "Гаалийн зуучлагч, мэдүүлэгч гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн, эсхүл хууль тогтоомжид заасан эрхээ хэтрүүлсэн бол" гэх зүйл заалтын дагуу 18 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд захиргааны зөрчлийн арга хэмжээ авч 10,8 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдуулсан байна..<br>**Хүрсэн түвшин:**<br>1. Уулзалт, санал асуулга зохион байгуулж Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журамд өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн авч Хуулийн хэлтэст дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>2. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18,9% хувиар засварт буцаалтын тоо буурсан байна. Засварт буцаалтанд дүн шинжилгээ хийн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд анхааруулах асуудлыг тухай бүр нэгдсэн viber группд тавин шийдвэрлэсэн.<br>3. Нийт 3 удаа сургалт зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан.<br>4. ГБМ нарт оногдуулсан зөрчлийн хэмжээ нэмэгдэж өнгөрсөн он 15 байсан бол энэ онд 22 болж 46.7 хувиар нэмэгджээ.. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ногдуулж байсан. ГЕГ-ын даргын тушаалаар 2022 онд эрхийг түдгэлзүүлсэн 5 ГБМ, 2023 онд ГБМ-ний эрхийг 6 сарын хугацаатай хүчингүй болгосон нийт 12 ГБМ байгаа нь гаалийн зуучлагчид ногдуулсан зөрчлийн тоо өмнөх 2022 оноос нэмэгдсэн байна. 2023 ондоо эрхийг сэргээсэн 7 байна. | | | | |
| 3 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ГЕГ-ын даргын 2023.04.17-ны өдрийн А/253 дугаар тушаалаар гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, нүүр тулсан харилцаанаас зайлсхийх, гадаад худалдааг хөнгөвчлөх зорилгоор УБГГ-т бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг туршилтаар эхлүүлсэн. ГЕГ-ын даргын 2023.06.15-ны өдрийн А/369 тушаалаар харьяа гаалийн газар, хороодын гаалийн бичиг баримтын | 1. Батлуулсан 2024 оны сургалтын төлөвлөгөөгний хэрэгжилтийг нь ханган ажилласан байна.<br><br>2. Гаалийн байгууллагын 2024 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд баримтуудыг хадгалж, хөтлөгдсөн баримтыг архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | **Биелэлт:**<br>2024 оны сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулсан.<br>Дотоод сургалт: Батлагдсан төлөвлөөгтэй уялдуулан 29 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 64 цагийн сургалтад нийт ГУАБ, ГУБ нар хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажилласан байна. Мөн тус төвөөс ГБМ, тээвэр зуучийн байгууллагуудад тээврийн зардал болон бусад анхаарах асуудлууд сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>Гадаад сургалт: 2 улсад зохион байгуулагдсан сургалтад ГУАБ 1, ГУБ 2 хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажилласан.<br>Бусад: 3 сургалтад ГУАБ-2, ГУБ-13 хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн байна.<br>2. 2024.06.17-ны өдөр БЦТ-ийн бичиг хэргийн албан тушаалд Ц.Мөнхболор томилогдсон.<br>АЕГ-ын даргын 2023 оны А/91 тушаалаар баталсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт болон салбарын жагсаалт"-ын дагуу 2024 онд хөтлөгдөх Байнга хадгалах, 70 жил хадгалах, Түр хадгалах нэрийн "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг боловсруулан, хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.<br>2024 онд үүссэн 5 чиглэлээр 17 хавтас архивласан. БТКУС, үнэ үнэлгээтэй холбоотой "ГУБ-ийн шийдвэрт гаргасан гомдлыг хянасан тухай шийдвэр"-үүдийг стандартын дагуу тус бүр 250 хуудастайгаар товъёог хийн архивын нэгжид хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 01.01-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрдүүлэлтийг цахим хэлбэрт шилжүүлэн Бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлсэн. Сангийн сайдын 2024.01.17-ны өдрийн 06 дугаар тушаал, ГЕГ-ын даргын А/123 дугаар тушаалаар ГЕГ болон дэргэдэх байгууллагын зохион байгуулалт, бүтэц орон тоог шинэчлэн баталсан. ГЕГ-ын даргын 2024.03.04-ны өдрийн Б/133 тоот тушаалаар тус төвд ажиллах ГУАБ, ГУБ нарыг томилоод байна. | 3. Заавал шалгах, өндөр эрсдэлийн шалгуурууд болон хяналт шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг сар бүр 5-аас доошгүй ААН, иргэн, бараагаар хийж, ЭУХ-т хүргүүлсэн байна.<br><br>4. Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах ААН-ын нэрсийг гарган, ЭУХ-т хүргүүлсэн байна. | 3. Тайлант хугацаанд бүрдүүлэлтийн цахим төвөөс эрсдэлийн шалгуур болох зөвшөөрөгдсөн шалгуурт 61 ААН, үл хамаарах шалгуурт 6 ААН, заавал шалгах шалгуурт 2 ААН-ыг оруулахаар нийт 69 "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг боловсруулан товч судалгааны хамтаар ГЕГ-ын ЭУХ-т 2024.02.01-ний өдрийн №5, 2024.04.12-ны өдрийн №52, 2024.05.06-ны өдрийн №58, 2024.05.30-ны өдрийн №72, 2024.09.05-ны өдрийн №125 тоот дотоод зурвасуудаар 5 удаа хүргүүлсэн.<br>Мөн экспортын 38 горимын кодыг заавал шалгах шалгуурт уяаж оруулах саналыг гарган 2024.12.02-ны өдрийн №175 тоот дотоод зурвасаар ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлээд байна.<br>4. Тайлант хугацаанд БББХГУБ нараас нийт 298 ААН-д БДШ оруулах саналыг давхардсан тоогоор 435 удаа кайс програмд оруулсан байна. 4 ААН-ын 2024 оны гаалийн бүрдүүлэлтэд товч судалгаа хийж, 2024.11.29-ны өдрийн №174 тоот дотоод зурвасаар БДШ-тад хамруулах саналыг гарган судалгааны хамтаар ГЕГ-ын БДШГ-т хүргүүлээд байна. Нийт 13 ААН-ын нэрийг БДШ-д хамруулахаар хүргүүлсэн..<br>**Хүрсэн түвшин:**<br>1. 2024 оны батлагдсан сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулагдсан 32 сургалтад давхардсан тоогоор 1280 алба хаагч хамрагдаж мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.<br>2. Гаалийн үнэ, үнэлгээ, барааны ангилалтай холбоотой 446 иргэн, 1439 ААН-ээс гаргасан хүсэлт, гомдол, маргааныг шийдвэрлэсэн шийдвэрийн мэдээллийг архивын нэгж үүсгэн хадгалсан. 2023 оны 11 хавтасыг архивлан архивт хүлээлгэн өгсөн. Мөн 2024 оны үүссэн 5 чиглэлээр 17 хавтас баримтыг архивласан.<br>БТКУС, үнэ үнэлгээтэй холбоотой "ГУБ-ийн шийдвэрт гаргасан гомдлыг хянасан тухай шийдвэр"-үүдийг стандартын дагуу тус бүр 250 хуудастайгаар товъёог хийн архивын нэгжид хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.<br>3. Эрсдэлийн шалгуур болох зөвшөөрөгдсөн шалгуурт 61 ААН, үл хамаарах шалгуурт 6 ААН, заавал шалгах шалгуурт 2 ААН-ыг оруулахаар нийт 69 "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг боловсруулан товч судалгааны хамтаар ГЕГ-ын ЭУХ-т 2024.02.01-ний өдрийн №5, 2024.04.12-ны өдрийн №52, 2024.05.06-ны өдрийн №58, 2024.05.30-ны өдрийн №72, 2024.09.05-ны өдрийн №125 тоот дотоод зурвасуудаар 5 удаа хүргүүлсэн.<br>4. Тайлант хугацаанд БББХГУБ нараас нийт 298 ААН-д БДШ оруулах саналыг давхардсан тоогоор 435 удаа сонгож кайс програмд оруулсан байна. 13 ААН-ын нэрийг БДШ-д хамруулахаар 2024.11.29-ний өдрийн №174 тоот дотоод зурвас болон бусад хэлбэрээр хүргүүлсэн.. | | |

| Зорилт 2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ГЕГ-ын даргын 2023.04.17-ны өдрийн А/253 дугаар тушаалаар гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, нүүр тулсан харилцаанаас зайлсхийх, гадаад худалдааг хөнгөвчлөх зорилгоор УБГГ-т бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг туршилтаар эхлүүлсэн. ГЕГ-ын даргын 2023.06.15-ны өдрийн А/369 тушаалаар харьяа гаалийн газар, хороодын гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийг цахим хэлбэрт шилжүүлэн Бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлсэн. Сангийн сайдын 2024.01.17-ны өдрийн 06 дугаар тушаал, ГЕГ-ын даргын А/123 дугаар тушаалаар ГЕГ болон дэргэдэх байгууллагын зохион байгуулалт, бүтэц орон тоог | 1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна.<br><br>2. Судалгаа, дүн шинжилгээг хийж, санал дүгнэлтийг удирдлага болон холбогдох нэгжүүдэд хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан байна.<br><br>3. Гаалийн газар, хороодын удирдлагуудтай харилцан мэдээлэл, солилцох, хамтран ажилласан байна. | **Биелэлт:**<br>1.Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоож, журам, зааврын хүрээнд бүрэн хангуулан, хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд 12,255.3 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 79 горимын кодоор 399,189 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн ба нийт 6,104.73 тэрбум төгрөгийн гаалийн болон бусад татвар, 4,133.2 сая төгрөгийн хураамжийг ногдуулан барагдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.<br>2.БЦТ-өөс гаалийн бүрдүүлэлт, бараатай холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийж, санал дүгнэлтийг удирдлага болон ГУБ нарт танилцуулан, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажилласан.<br>ГЕГ-ын БАУХ-т 2024.03.01 өдөр 24 тоот дотоод зурвасаар ГГХ-ны бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, интернэтээр олон нийтэд тараасан үнийг харьцуулсан судалгаа,<br>□ 2024.02.19 өдөр 14 тоот дотоод зурвасаар АНУ суудлын автомашин,<br>□ 2024.03.05 өдөр 26 тоот дотоод зурвасаар БНХАУ-ын чирэгч автомашин болон чиргүүл,<br>□ 2024.04.19 өдөр 53 тоот дотоод зурвасаар цистерн, тавцант, ачааны, хагас ачааны вагоны судалгааг хийж хүргүүлэн батлагдсан судалгаануудын дагуу үнийг баримтлан ажиллаж байна.<br>БЦТ дотооддоо дараах судалгаа дүн шинжилгээг хийж төвийн даргад болон нийт ГУБ нарт танилцуулан ажилласан:<br>□ БТКУС 2716 /Цахилгаан эрчим хүч/ 3 жил, 6801, 6810 /боржур/, 7005 /шил/, 8704 /өөрөө буулгагч/, 8705 /миксер/, 9018 /эм эмнэлгийн хэрэгсэл/ бараануудын бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийж алдаа, цаашид анхаарах асуудлыг танилцуулж алдааг засуулан ажилласан.<br>□ Дэд даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу НӨАТ-ын баримтаар баталгаажуулсан тээврийн зардал,<br>□ БНХАУ-ын 8703 суудлын автомашины бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийж алдаа, анхаарах зүйлс, экспортлогч улсад ашиглагдаж буй интернэт сайтуудад хэрхэн ажиллах талаар танилцуулга,<br>□ Gaali.mn сайтаар цахимаар өөрөө мэдүүлсэн ААН, иргэн,<br>□ Нийт системийн хэмжээний түр горимын 2020-2024 оны 5-н жилээр,<br>3. 3. Энэ ажлын хүрээнд бүх ГГХ-ны дарга, ХША, ГБА-ны дарга, ГУАБ, ГУБ, ГУАБ, ГУБ нартай дараах асуудлуудаар уялдаа холбоотой ажиллаж мэдээлэл, зөвлөмж, чиглэлээр хамтарч ажилласан. | 01.01-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинэчлэн баталсан. ГЕГ-ын даргын 2024.03.04-ны өдрийн Б/133 тоот тушаалаар тус төвд ажиллах ГУАБ, ГУБ нарыг томилоод байна.<br><br>2023 оны 12 сарын "Гаалийн захиргааны статистикийн мэдээлэлд зарим үзүүлэлтээр хийгдсэн дүн шинжилгээ"-нд гаалийн мэдүүлгийн алдааг 2023 оны эхний 12 сард 5529 гэж тусгасан байна.<br><br>Мөн 2024.04.02-ны өдрийн байдлаар 2023 оны "Гааль зөвшөөрөв" төлөвт ороогүй 92 импортын гаалийн бүрдүүлэлт байна. Үүнээс:<br><br>- Бичиг баримтын шалгалт хийгдсэн-61<br><br>- Татвар төлсөн-16<br><br>- Засварт буцаасан-15 | | □ Татвар орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр УБГГ-тай биечилсэн 1, ЗҮГГ-тай онлайн 2, СШГГ-тай биечилэн 2 удаа, нийт 5 удаагийн уулзалт,<br>□ ЗҮГГ-ын холбоо баригчаар дамжуулж 62 удаагийн хамтарсан манифестийн лавлагааг авсан..<br>**Хүрсэн түвшин:**<br>1. Татварын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,329.6 тэрбум төгрөгөөр буюу 27.8 хувиар, хураамжийн дүн 789.5 сая төгрөгөөр буюу 27.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 401, 4011, 402, 4021, 403, 4031 горимоор гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдөж, дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор 657.8 сая ам.долларын статистик дүн бүхий бараа татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан нь өмнөх оныхоос 128.2 хувиар өссөн байна.<br>2. Гаалийн тариф, татварын тухай хуулийн 15.2.2.4-д заасны дагуу Чирэгч автомашин болон бүх төрлийн чиргүүл, АНУ-аас импортолж байгаа суудлын автомашин, Замын-Үүд дэх гаалийн газрын хилийн үнийн судалгааг шинэчлэн батлуулсаныг дагуу нэмж ногдуулсан татварын зөрүү нийт 94 тэрбум төгрөг. Холбогдох судалгаа дүн шинжилгээндийг хийснээр гарсан алдааг тухай бүр засуулж, цаашид анхаарах асуудлыг танилцуулсанаар алдаа гаргах нь багасаж байна.<br>3. ЗҮГГ-ын холбоо баригчаар дамжуулан авсан хамтарсан манифестийн мэдээллээс гаалийн байгууллагад багаар мэдүүлснийг лавлагааны дагуу гаалийн нэгж үнийг дахин хянаснаар 406,9 сая төгрөгийн татвар /манифестын лавлагааны 28.5 хувь/, хамтарсан манифестийн мэдээлэл гаалийн байгууллагад мэдүүлсэнтэй таарсан болон мэдүүлснээс бага үнийн дүнтэй ирсэн хэдий ч уялдуулан хэрэглэх үнийн аргаар гаалийн нэгж үнийг дахин хянасан 520,6 сая төгрөгийн татварыг /лавлагааны 71.5 хувь/ ногдуулж барагдуулсан байна.<br>БЦТ-ийн ГУБ нар гаалийн бүрдүүлэлтэд бичиг баримтын шалгалт хийх явцдаа гаалийн болон бусад хууль тогтоомж зөрчсөн нийт 115 үйлдлийг илрүүлэн 64 зөрчлийн бүрдүүлэлтийн цахим төвийн эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 75.84 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэн 71.91 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна. Зөрчлийн шинжтэй 51 үйлдлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн дагуу харьяа гаалийн газар, хороодын эрх бүхий албан тушаалтанд шилжүүлсний дагуу 64.34 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэн 63.92 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна.. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн | 2023 онд бичиг баримтын шалгалтын явцад нийт 87 зөрчлийг илрүүлэн 72,8 сая төгрөгөөр торгон, 7,65 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн байна. | 1. Мэдүүлэгчийн гаргасан алдааг илрүүлсэн тоо, нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.<br><br>2. Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 3 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.<br><br>3. Барааны ангиллын луйврыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.<br><br>4. Гааль зөвшөөрөв төлөвөөс засварт буцааж мэдүүлэгт засвар оруулсан байдлыг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар бууруулна. | **Биелэлт:**<br>БЦТ-д 2024 оны эхний 11 сард 399593 импортын, 5958 экспортын, нийт 405551 гаалийн мэдүүлгийн 2111174 бичлэгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.<br>Тайлант хугацаанд нийт 1800 гаалийн зуучлагч аж ахуйн нэгж, байгууллага, ГБМэргэжилтэн болон зуучлагчид 88699 удаагийн засварт буцаалтаас дагалдах баримт нэмсэн 47851 засварт буцаалтыг хассанаар 40848 бичлэг засварласан.<br>2023 онд 309181 гаалийн мэдүүлгээр 1788863 бичлэгийг хянаж, 63207 бичлэг засварт буцаасан нь нийт бичлэгийн 3,5% эзэлж байсан бол 2024 онд 405551 гаалийн мэдүүлгээр 2111174 бичлэгийг хянаж 88699 бичлэгийг засварт буцаасан нь нийт бичлэгийн 4,2% эзэлж байгааг харьцуулбал мэдүүлгийн тоо 96370, бичлэгийн тоо 322311, засварт буцаалт 1,8% өсөлттэй харагдаж байна.<br>2024 онд бичиг баримтын шалгалт хийх явцад ГТХууль, ГТГТТХ зөрчсөн нийт 116 зөрчлийг илрүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Зөрчлийн тухай хуулийн 9 зүйлчлэлээр 140.19 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 136.14 сая төгрөгөөр торгож 276.33 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.<br>2023 онд 87 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 7 зүйлчлэлээр 7.65 сая төг-ийн татварыг нөхөн төлүүлэн, 72.83 сая төг-ийн торгуулийг ногдуулан.<br>2023 оны үзүүлэлттэй харьцуулахад зөрчлийн тоо 29 буюу 33.3 хувь, нөхөн төлсөн татварын дүн 72.83 сая төг буюу 1732 хувь, торгуулийн дүн 63.32 сая төг буюу 86.94 хувиар тус тус нэмэгдсэн.<br>ГУБ нарыг мэргэшүүлэх чиглэлээр 97 бүлгийн барааг хуваарилан БЦТ-ийн даргаар батлуулан хариуцсан бүлгийн барааны ГБ-д холбогдох хууль тогтоомж, бүрдүүлэлтийн судалгааг хийлгэж тусдаа хавтас үүсгэн санг бүрдүүлсэн.<br>Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж, ангиллын луйврыг илрүүлж барааны ангиллын код хянаж 831 бичлэгт өөрчлөлт оруулсан.<br>Автомашины болон хил орчмын үнийн судалгааг хийж, ГЕГ-ын холбогдох нэгжээр хянуулан баталгаажуулж, гаалийн үнийг тодорхойлоход ашигласан.<br>2024 оны хилийн үнийн судалгаанд үндэслэн 56.6 тэрбум төгрөг, татвар нэмж төлүүлсэн.<br>БЦТ-ийн албан хаагч нарыг мэргэшүүлэх, алдаа дутагдал гаргахгүй хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор мэдээллийн цагийг долоо хоног бүр Мягмар гаригт 7:30 минутад хийж хэвшсэн. 29 удаагийн сургалт, ярилцлага хийсэн.<br>Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр 2 удаагийн аяныг зарлан явуулсан..<br>**Хүрсэн түвшин:** | 01.01-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Бүрдүүлэлтийн цахим төвөөс гаалийн мэдүүлгийн баазыг үнэн зөв бүрдүүлэх, гаалийн болон бусад татварыг үнэн зөв ногдуулж барагдуулах, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнийг чадавхжуулах чиглэлээр нэлээд анхаарч тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласнаар тодорхой үр дүнд хүрч байна.<br>2024 онд 18 зуучлагч байгууллагын 21 ГБМ-ий 22 зөрчлийг илрүүлэн ЗТХ-ийн 11.21.14-д заасны дагуу тус бүр 300000 төгрөгөөр торгосон. ГБМ-д хариуцлага тооцсон байдал 2023 онтой харьцуулбал зөрчлийн тоо 7 буюу 46.6%, торгууль 2.1 сая буюу 46.6% тус тус нэмэгдсэн байна.<br>2024 онд 116 зөрчлийг илрүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Зөрчлийн тухай хуулийн 9 зүйлчлэлээр 140.19 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 136.14 сая төгрөгөөр торгож 276.33 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. 2023 оны үзүүлэлттэй харьцуулахад зөрчлийн тоо 29 буюу 33.3 хувь, нөхөн төлсөн татварын дүн 72.83 сая төг буюу 1732 хувь, торгуулийн дүн 63.32 сая төг буюу 86.94 хувиар тус тус нэмэгдсэн.<br>Бүрдүүлэлтийн цахим төвөөс гаалийн улсын байцаагч нарын мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэн барааны ангилал, гаалийн үнийг худал мэдүүлсэн алдааг засч татварын нэмж төлүүлэн 78 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 140.18 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэн, 107.29 сая төгрөгөөр торгосон, 3 хуулийн этгээдийг тус бүр 3 сая төгрөгөөр торгох хариуцлага хүлээлгэсэн.<br>Тайлант хугацаанд нийт 8583 мэдүүлгийг "гааль зөвшөөрөв" төлөвөөс засварласан байна. Үүнээс 4197 мэдүүлгийг тухайн өдөрт нь, 1046 мэдүүлгийг ГЕГ-аас шалгуулахаар буцаасан, 3340 мэдүүлгийг гаалийн газар, хороод ГЕГ-ын Статистикийн хэлтэст хүсэлт илгээн засварласан байна.<br>нийт бүрдүүлэлтийн тоо өмнөх оны мөн үеэс 96548 мэдүүлгээр буюу 31.27%-иар өссөн байна.<br>"Гааль зөвшөөрөв" төлөвөөс 2023 онд буцаан зассан 4194 мэдүүлэг нь тухайн оны нийт бүрдүүлэлтийн 1.36%-ийг эзэлж байсан бол 2024 онд зассан 3849 мэдүүлэг нь нийт бүрдүүлэлтийн 0.95%-ийг эзэлж байна. Энэ нь 2024 оны эхний 11 сард "гааль зөвшөөрөв" төлөвөөс буцаан заасан мэдүүлгийн тоо 345 мэдүүлэг буюу 8.23%-иар буурсан сайн үзүүлэлттэй байна.<br>БЦТ-ийн албан хаагч нарыг мэргэшүүлэх, алдаа дутагдал гаргахгүй хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор мэдээллийн цагийг долоо хоног бүр Мягмар гаригт өглөө бүр ГУБ нарт хийж Мэдээлэл, анхааруулга өгч хэвшсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | 2023 онд 24 удаагийн горимын шаардлага зөрчиж хугацаа хэтрүүлсэн. 298 гаалийн бүрдүүлэлтийн горим өөрчлөн мэдүүлгийг татгалзсан төлөвт оруулсан байна. /ГЕГ-ын Хяналт бүрдүүлэлтийн газрын 2023 оны тайлангаас авсан тоон үзүүлэлт/ | 1. Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.<br><br>2. Түр горимд байршуулсан бараанд хяналтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн байна, гаалийн газар, хороодтой хамтарч мэдээлэл солилцон ажилласан байна.<br><br>3. Гаалийн бүрдүүлэлтийн явцад хөнгөлөлттэй болон нэн тааламжтай тарифыг нягтлан шалгаж, дүн шинжилгээ хийж, илэрсэн алдааг засварлаж ажилласан байна. | **Биелэлт:**<br>1. Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоож, журам, зааврын хүрээнд бүрэн хангуулан, хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд 12,255.3 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 79 горимын кодоор 399,189 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн ба нийт 6,104.73 тэрбум төгрөгийн гаалийн болон бусад татвар, 4,133.2 сая төгрөгийн хураамжийг ногдуулан барагдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Татварын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,329.6 тэрбум төгрөгөөр буюу 27.8 хувиар, хураамжийн дүн 789.5 сая төгрөгөөр буюу 27.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 401, 4011, 402, 4021, 403, 4031 горимоор гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдөж, дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор 657.8 сая ам.долларын статистик дүн бүхий бараа татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан нь өмнөх оныхоос 128.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2. Түр горимын 10-н кодоор 230891.6 мян.ам.долларын үнийн дүн бүхий бараа, тээврийн хэрэгсэлд 7155 гаалийн мэдүүлгээр түр горимын оруулах болон гаргах бүрдүүлэлт хийгдсэн. /экспортын 733 мэдүүлэг 101986.6 мян.ам.доллар, импортын 6422 мэдүүлэг 128905.0 мян.ам.дол/<br>ГТХ-ийн 95.1-р зүйлд заасан гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан, гаргасан барааг бүрмөсөн орох горимд шилжсэнээр 2024 оны эхний 11 сард 30 тэрбум 584 сая төгрөгийг татвар улсын төсөвт төвлөрсөн байна.<br>Түр горимын мэдүүлгийн хаалтыг харуулбал:<br>- Хугацаанд хаагдсан - 9683<br>- Хугацаа болоогүй - 1897<br>- Хугацаа хэтэрсэн - 95 гаалийн мэдүүлэг тус тус байна.<br>3. Япон-Монголын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болон Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн /АПТА/ хөнгөлөлттэй тарифтай холбоотой гаалийн бүрдүүлэлтэнд хяналт тавин ажиллаж алдаатай мэдүүлгийг тухай бүр хариуцсан ГУБ-д мэдэгдэж мэдүүлгийг зассан. Японы хөнгөлөлттэй тарифаар бүрдүүлэлт хийсэн 02-2091010-24-I31401 дугаартай мэдүүлгийн гарал үүслийг ГБМ андуурч хийсэн байсныг зөв болгуулсан бол 02-2111005-24-I30325 дугаартай мэдүүлгийн алдааг засуулан 3'630'134.56 төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. Цахимаар өөрөө мэдүүлсэн иргэн, ААН-ийн хөнгөлөлттэй тарифаар андуурч илгээсэн бүрдүүлэлтийг нягтлан шалгаж 24 мэдүүлгийг засуулан 227'625.07 төгрөгийн татвар нөхөн төлүүлсэн..<br>**Хүрсэн түвшин:**<br>1. Тайлант хугацаанд нийт 12,255.3 сая ам.доллар бүхий 399,189 импортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн | 01.01-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байдалтай харьцуулахад статистик дүн 2,624.45 сая ам доллар илүү буюу 27.25 хувийн өсөлттэй, 97,032 бүрдүүлэлт илүү буюу 32.11 хувийн өсөлттэй үзүүлэлттэй байна. Нийт экспорт 816.3 сая долларын статистик дүн бүхий 6,143 экспортын бүрдүүлэлт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад статистик дүн 163.25 сая ам.доллараар бага буюу 16.67 хувь, бүрдүүлэлтийн тоо 480 буюу 7.25 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.<br>2. Тайлант хугацаанд хугацаанд горимын 10-н кодоор 230891.6 мян.ам.долларын үнийн дүн бүхий бараа, тээврийн хэрэгсэлд 7155 гаалийн мэдүүлгээр түр горимын оруулах болон гаргах бүрдүүлэлт хийгдсэн. Тайлант хугацаанд 7820 мэдүүлгээр 296.8 сая ам.долларын бараа, тээврийн хэрэгсэлд түр горимын хаалтын бүрдүүлэлт хийсэн байна. /горимын код 120, 133, 300, 420-422, 442, 621-624/ Импортын түр горимын мэдүүлгийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 5.5 хувь өссөн боловч барааны үнийн дүн 10.2 хувь, татварын дүн 2.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Гаалийн тухай хуулийн 95.1-р зүйлд зааснаар гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан, гаргасан барааг бүрмөсөн орох горимд шилжсэнээр 2024 оны эхний хагас жилд 7 тэрбум 409 сая төгрөгийг татвар улсын төсөвт төвлөрсөн байна. 2024 оны 8 дугаар сард зохион байгуулсан "Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, хууль бус худалдаатай тэмцэх аян"-ны хүрээнд 2020-2024 оны түр хугацаагаар импортлогдсон барааны судалгааг хийсэн ба үүний үр дүнд хугацаа хэтэрсэн 36 гаалийн мэдүүлгийн жагсалт гарган холбогдох газар, хороонд мэдэгдэн заавар, зөвлөгөөг өгч ажилласнаар 20 мэдүүлэг түр горимын хаалтын бүрдүүлэлтийг хийсэн.<br>3 2024 онд Нэн тааламжтай тарифаар 11896.86 сая ам.доллар, ердийн тарифаар 22.7 сая ам.доллар, хөнгөлттэй тарифаар 334.9 сая ам.долларын үнийн дүн бүхий бараанд гаалийн бүрдүүлэлт хийж нийт 6103.99 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Японы хөнгөлөлттэй тарифаар бүрдүүлэлт хийсэн гаалийн мэдүүлэг 17.8 хувиар буурсан бол АПТА хөнгөлөлттэй тарифаар бүрдүүлэлт хийсэн мэдүүлэг 6 дахин өссөн байна. Нийт гаалийн бүрдүүлэлтийн 50 гаруй хувийг 8703 бүлгийн бараа болох автомашин эзэлж байна.. | - | |
| 4 | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойл | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ГЕГ-ын даргын 2023.04.17-ны өдрийн А/253 дугаар тушаалаар гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, | 1. Эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах, гаалийн үнийн | **Биелэлт:**<br>1. "Автомашин, тоног төхөөрөмжийн бүрдүүлэлтийн хэсэг"-ийн тусад зохион байгуулсан, автомашины USS дуудлага худалдааны албан ёсны эрхийг авсан, мөн төмрийн нээлттэй биржийн цахим хуудас www.lgmi.com-т хандах 1 жилийн албан ёсны эрхийг БАҮХ-ээс иргүүлснийг үнийн хяналтын зорилгоор ашиглаж байна. Эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах ажлын хүрээнд зөвшөөрөгдсөн шалгуурт 61 ААН, ул | 01.01-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ох чиглэлээр зохион байгуулсан ажил | | нүүр тулсан харилцаанаас зайлсхийх, гадаад худалдааг хөнгөвчлөх зорилгоор УБГГ-т бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг туршилтаар эхлүүлсэн. ГЕГ-ын даргын 2023.06.15-ны өдрийн А/369 тушаалаар харьяа гаалийн газар, хороодын гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийг цахим хэлбэрт шилжүүлэн Бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлсэн. Сангийн сайдын 2024.01.17-ны өдрийн 06 дугаар тушаал, ГЕГ-ын даргын А/123 дугаар тушаалаар ГЕГ болон дэргэдэх байгууллагын зохион байгуулалт, бүтэц орон тоог шинэчлэн баталсан. ГЕГ-ын даргын 2024.03.04-ны өдрийн Б/133 тоот тушаалаар тус төвд ажиллах ГУАБ, ГУБ нарыг томилоод байна. | хяналтын тогтолцоонд шинэ хандлага төлөвшүүлсэн байна.<br><br>2. Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна.<br><br>3. Импортын барааны хэлцлийн үнийн баазыг бүрдүүлж, ГЕГ-ын холбогдох нэгжээс баталсан үнийн мэдээлийн санг гаалийн үнийг тодорхойлоход ашигласан байна.<br><br>4. Автомашины болон хил орчмын үнийн судалгааг хийж, ГЕГ-ын холбогдох нэгжээр хянуулан баталгаажуулж, гаалийн үнийг тодорхойлоход ашигласан байна.<br><br>5. Судалгаа, дүн шинжилгээнүүдийг гаалийн бүрдүүлэлтийн, | хамаарах шалгуурт 6 ААН, заавал шалгах шалгуурт 2 ААН, экспортын 38 горимын кодыг заавал шалгах шалгуурт хамаарах санал 6 удаа хүргүүлсэн.<br>2. Туршилтын 10 сарын 01-ны өдрөөс эхлэн Toyota, Prius автомашины үнийн хяналтыг цахимжуулсан.<br>3. 2024 оны эхний 11 сарын байдлаар 2 093 867 бичлэгт импортын гаалийн бүрдүүлэлт хийж, 74% буюу 1 545 671 барааг хэлцлийн үнийн аргаар, 26% буюу 548196 барааг гаалийн үнэлгээний бусад аргаар тодорхойлсон байна. Импортын барааны үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд хэлцлийн үнийн санд 1024293 барааны мэдээлэл, баталгаажсан санд 224725 мэдээлэл, нягтлан шалгах санд 1700 нийт 1250717 мэдээлэл оруулсан.<br>4. АНУ, БНХАУ-аас импортолж байгаа автомашины, ОХУ-аас импортолсон вагоны судалгааг хийж, БАҮХ-р хянуулан Cais-ийн үнийн судалгаа дэд цэсэнд байршуулан, БАҮХ, ЗҮГГ-тай хамтран хилийн үнийн судалгааг хийж үнийн хяналтын зорилгоор ашиглаж байна.<br>5. Тайлант хугацаанд 334 өдөр орлогын мэдээг татварын төрөл, гаалийн газар хороо, бүрдүүлэлтийн тоо, үнэлгээний арга /мэдүүлэг, бичлэг, иргэн, ААН/ -г гарган дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангаж байсан. Тайлант хугацаанд 11 нэр төрлийн барааны судалгаа хийсэн.<br>6. Бүрдүүлэлтийн явцад барааны ангиллын код хянаж 928 бичлэгт өөрчлөлт оруулсан ба бүрдүүлэлтийн явцад 47 гаалийн мэдүүлгээр 403 горимоор мэдүүлсэн барааны ангиллын кодыг хянаж буруу мэдүүлснийг илрүүлж 400 горимын кодоор бүрдүүлэлт хийсэн.<br>7. БНХАУ-д үйлдвэрлэгдсэн автомашины vin17.com сайтаар арлаар хайлт хийж, лавлах санд мэдээлэл илгээх, мөн 87.05, 84, 85, болон 90 дүгээр бүлэгт хамаарах барааны бичиглэлийн талаар 01-8/2037 тоот албан бичгээр чиглэл өгсөн.<br>8. Энэ онд ГБМ-ээс ирүүлсэн 6 оноосон нэр, 434 үйлдвэрлэгч 115 хөдөлгүүрийн багтаамж, 3407 модель, 2078 кузовын мэдээлэл нэмж лавлах санг баяжуулсан..<br>**Хүрсэн түвшин:**<br>1. Бүх төрлийн автомашин, хүнд машин механизмын үнийн хяналтыг сайжирсан. Япон улсаас импортолсон автомашины хувьд эрсдэл тооцон USS-ээс дуудлага худалдааны эрхээр мэдүүлсэн үнийг шалгаж 27 автомашин дээр 67.7 сая төгрөг нөхөн төлүүлэн, 33.8 сая төгрөгийн торгууль төлүүлсэн. ЭҮХ хүргүүлсэн шалгуурын дагуу бүрдүүлэлтийн явцад 67 ААН хяналтын төлөв өөрчлөгдөж, бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа буурах боломжтой болно.<br>2. 10-11 сард Toyota, Prius маркийн суудлын автомашин 10331 импортолсон ба 91.8 хувийг хэлцлийн үнийг аргаар, 8.2%-ийг бусад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
